

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Эрх зүйн бүрэн чадамжтай,
25-60 хүртэл насны Монгол Улсын иргэн

Тухайн анхан шатны
шүүхийн харьяаллын
нутаг дэвсгэрт
байнга оршин суудаг

Эрүүгийн хариуцлага
хүлээж байгаагүй



Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

- Шүүх хуралдааныг орхин явах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;
- Шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэхгүй байх;
- Хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзах;
- Хэргийн талаар нотлох баримт цуглуулах;
- Өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэргийн талаар мэдээлэл өгөх.



ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ



Тухайн орон нутгийн хүн
амын тоог харгалзан
баталсан жишиг тоог
үндэслэн нэрс гаргуулахаар
хүргүүлнэ.



Иргэдийн төлөөлөгчийн
нэрсийн жагсаалтыг
тухайн шүүхийн
Тамгын газрын дарга
баталгаажуулна.



Нэрсийг санамсаргүй
аргаар цахим хэлбэрээр
улсын бүртгэлийн
мэдээллийн сангаас
сонгож, 21 хоногийн дотор
хүргүүлнэ.



Нутгийн захиргааны
байгууллага нэрсийг
нягтална.



Хуульд заасан
шаардлага хангаж
байгаа эсэхийг
нягтална

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ

МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ



ШҮҮХИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН НЭГДСЭН СИСТЕМ

Шүүх хуралдааны тов гармагц иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас шүүх хуралдаан бүрд 10 хүний нэрсийн жагсаалтыг цахимаар эрэмбэлэн тохиолдлын журмаар сонгоно. Ийнхүү шүүх хуралдаанд сонгосон нэрсийг Тамгын газрын дарга дэд жагсаалтаар батална.

Нэрсийн дэд жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг цахимаар эрэмбэлэгдсэн дарааллаар шүүх хуралдаанд оролцуулна.

Тамгын газрын
даргын тушаал
“Дэд жагсаалт
батлах” тухай

.....
.....

ДАРГА Б.БОЛД

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

Шүүхийн иргэдийн төлөөлөгч

Анхан шатны журмаар эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэд, олон нийтийг төлөөлөн оролцож, санал дүгнэлтээ гаргах эрх бүхий Монгол Улсын иргэнийг шүүхийн иргэдийн төлөөлөгч гэнэ.

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 66 дугаар зүйл:

66.3.1. шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох;

66.3.2. шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, зохигч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, гэрч, шинжээчид асуулт тавих;

66.3.3. хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, шүүгдэгч, зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах;

66.3.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.4 дүгээр зүйл:

2.1. шүүх хуралдааны явцад нотлох баримт шинжлэн судлахад оролцож, шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр асуулт тавих;

2.2. шүүгдэгчийн гэм буруугийн талаар санал бичих, уншиж сонсох.



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйл:

86.2.1. хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;

86.2.2. энэ хуулийн 91 дүгээр зүйлд заасан үндэслэлээр шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах, нотлох баримтыг шинжлэхэд оролцох;



86.2.3. зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих;

86.2.4. хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар бичгээр дүгнэлт гаргах;

86.2.5. шүүгчдийн зөвлөгөөнөөс хуваарилсан шүүх хуралдааныг таслахгүй байх;

86.2.6. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг задруулахгүй байх;

86.2.7. энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.

86.3. Энэ хуулийн 86.2.4-т зааснаар хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонгоно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйл

113.1. Иргэдийн төлөөлөгч маргааны үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар дүгнэлтээ бичгээр гаргана. Эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, амаар дүгнэлт гаргаж болно.

113.2. Иргэдийн төлөөлөгч дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонгоно.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйл:

75.2.1. шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;

75.2.2. нотлох баримт шинжлэхэд оролцох;

75.2.3. хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих;

75.2.4. нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах;

75.2.5. хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах;

75.2.6. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх;

75.2.7. энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.

75.3. Энэ хуулийн 75.2.5-д зааснаар хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар гаргасан иргэдийн төлөөлөгч дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонгоно.

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ

- Хувийн болон албаны ажлаа зохицуулж, шүүхэд заавал хүрэлцэн ирэх;
- Шүүх хуралдаанд оролцох, хуралдааны дэгийг сахих;
- Санал, дүгнэлтээ бичгээр гаргаж, шүүх хуралдаанд танилцуулах;
- Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэн шүүх хуралдааныг таслахгүй байх;
- Өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх;
- Хэргийн оролцогчтой төрөл садан, гэр бүлийн харилцаатай, хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хувийн ашиг сонирхлын зөрчилтэй бол уг шүүх хуралдаанд оролцохоос өөрөө, сайн дураараа татгалзах үүрэгтэй.



ШҮҮХЭД ХҮРЭЛЦЭН ИРЭХ

Шүүхийн мэдэгдэх хуудас, мэдэгдэл

Шүүх хуралдаанд сонгогдсон иргэнд 5-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэнэ.

Шүүхийн мэдэгдэх хуудас – Шүүхийн иргэдийн төлөөлөгчид оршин суугаа эсхүл ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ.

Утсаар - Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээллийн санд бүртгэлтэй утасны дугаараар мэдэгдэнэ.

Мэдэгдэл - Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ.



Шүүхэд заавал хүрэлцэн ирэх

Шүүхийн мэдэгдэх хуудас авсан иргэн шүүх хуралдаанд оролцохын тулд хувийн болон албаны ажлаа зохицуулах үүрэгтэй. Шүүхийн иргэдийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухайгаа Тамгын газарт даруй мэдэгдэнэ.

Хэрэв тухайн иргэн ажил эрхэлдэг бол ажил олгогчид энэ тухай мэдэгдэж чөлөө авах эрхтэй.

Ажил олгогч шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон ажилтанд чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэгтэй. Энэхүү үүргийг зөрчсөн тохиолдолд ажил олгогчид хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Цаг баримтлах

Шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаан болохоос нэгээс доошгүй цагийн өмнө шүүхийн байранд шүүхийн мэдэгдэх хуудас, иргэний үнэмлэхтэйгээ



ирнэ. Шүүхийн Тамгын газрын ажилтан шүүхийн иргэдийн төлөөлөгчийг угтаж авна. Тамгын газрын ажилтан шүүхийн иргэдийн төлөөлөгчид эрх, үүрэг, хүлээх хариуцлага, хуралдааны дэгийн талаар танилцуулж, мэдээллээр хангаж, шүүх хуралдаанд оролцуулах бэлтгэлийг хангахад тусална. Цаг тулгаж ирснээр хуралдаанаас өмнө бэлтгэл хангагдахгүй, шүүх хуралдаан хойшлогдох сөрөг үр дагавартай.

Хувцаслалт

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны оролцогч боловч тусгайлсан өмсгөл хэрэглэхгүй. Шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ирэхдээ өөрт тохиромжтой, зохистой байдлаар хувцаслана. Үсний засалт, нүүрний будаг, бөгж, ээмэг, хүзүүний зүүлт нь төлөв даруу, бусдын анхаарлыг хэт татахгүй байвал зохино. Шүүхийн иргэдийн төлөөлөгч таны хувцаслалт, биеэ авч яваа байдал нь шүүхийг хүндэтгэж буйн илэрхийлэл юм.



Хариуцлага

Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг

1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан хүн хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хурлын үйл ажиллагаанд оролцохоос санаатайгаар зайлсхийсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хуульд заасан ажил олгогч шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа чөлөө олгоогүй, эсхүл аливаа байдлаар саад учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. (1 нэгж 1000 төгрөгтэй тэнцүү)



ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОХ

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцох шүүх хуралдаан

Анхан шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх дараах шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч заавал оролцоно.



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

(Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3)

- Эрүүгийн хуулийн тусгай ангид найман жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг;
- Шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг ээдрээ төвөгтэй гэж үзсэн шүүгчийн саналыг Ерөнхий шүүгч дэмжсэн.

ИРГЭНИЙ ХЭРЭГ

(Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйл)

- Гэм хорын хохирол гаргуулах хэрэг

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

(Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйл)

- Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээс хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан;
- Захиргааны хэм хэмжээний акттай холбоотой;
- Тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон.

Шүүх хуралдаан эхлэхээс өмнө шүүхийн иргэдийн төлөөлөгч таны мэдэх, анхаарах зүйлс

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй болохоо илэрхийлсэн мэдэгдэл бөглөнө. (Мэдэгдлийн загварыг 37-р хуудсаас харна уу)

Ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд тухайн шүүх хуралдаанд оролцохоос татгалзах хүсэлт гаргана. (Хүсэлтийн загварыг 39-р хуудсаас харна уу)

Хэргийн оролцогчтой төрөл садан, гэр бүлийн харилцаатай, хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хувийн ашиг сонирхлын зөрчилтэй бол уг шүүх хуралдаанд оролцохоос өөрөө, сайн дураараа татгалзах үүрэгтэй.

Хэрэв өөрөө сайн дураар татгалзан гараагүй бол шүүх хуралдааны бусад оролцогч (прокурор, өмгөөлөгч, шүүгдэгч, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд) татгалзана.

Шүүх хуралдаан тасралтгүй явагдах тул хуралдаан эхлэхээс өмнө хооллох, бие засах зэргээр хувийн бэлтгэлээ сайтар хангасан байна.

Хавтаст хэрэгтэй танилцах

Хэргийн холбогдолтой баримт, нотолгоог тусгай хавтаст эмхэтгэсэн байдаг. Шүүхийн иргэдийн төлөөлөгч хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх эрхтэй. Өөрөөр хэлбэл хэрэг, маргааны талаар урьдчилсан мэдээлэлтэй болж, шүүх хуралдаанд бэлтгэлтэй оролцох нь чухал юм. Шүүх хуралдааны үед талуудын мэтгэлцээн, нотлох баримт шинжлэн судлах явцыг анхааралтай сонсож, ойлгомжгүй зүйлээ асууж тодруулж болно.



Тангараг өргөх

Шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаан эхлэхээс өмнө хуралдааны танхимд тангараг өргөнө. Тангараг өргөх ажиллагааг шүүх хуралдаан даргалагч удирдан явуулна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг тангараг өргөхөд шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаанд оролцогчид босож хүндэтгэл үзүүлнэ. Шүүхийн иргэдийн төлөөлөгч Монгол Улсын Төрийн сүлд рүү харан цэх зогсож, тангаргийг тод дуудаж дууссаны дараа Төрийн сүлдэнд мэхийн ёсолно. Тангараг өргөсөн шүүхийн иргэдийн төлөөлөгч “Монгол Улсын шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тангаргийн хуудас” гэсэн гарчигтай “Шүүхийн иргэдийн төлөөлөгч би хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааны талаар хэнээс ч хараат бусаар санал, дүгнэлт гаргахаа батлан тангараглая” гэсэн бичвэр бүхий тангаргийн хуудаст тангараг өргөсөн он, сар, өдөр, шүүхийн нэр, эцэг, (эх)-ийн нэр, өөрийн нэрээ бичиж гарын үсэг зурснаар тангараг өргөх ажиллагаа өндөрлөнө. (Тангарагийн хуудасны загварыг 40-р хуудсаас харна уу)



Шүүх хуралдааны дэгийг сахих

Эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдаан бүр өөр өөрийн онцлогтой, хуульд заасан дэгийнхээ дагуу явагдана. Хуралдаанд оролцогч бүр энэхүү дэгийг сахих, шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.



ШҮҮХ ХУРАЛДААНЫ НИЙТЛЭГ ЖУРМЫН ТАЛААР ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

82 дугаар зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам

82.1. Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.

82.2. Шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно.

Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас суудлаасаа босч чадахгүй бол хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаар үг хэлж болно.

82.3. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хуралдааны танхимд орж ирэх, шүүхийн шийдвэрийг уншиж сонсох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.

82.4. Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан этгээдийг хуралдаан даргалагчийн шийдвэрээр шүүх хуралдааны танхимаас гаргаж, энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.

82.5. Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, бусад оролцогчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлэг, дүгнэлтийг сонсохгүйгээр хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл үргэлжлүүлэн явуулах бөгөөд хуралдаан даргалагч уг этгээдэд түүний байхгүйд хэлэлцсэн асуудлыг танилцуулна.



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

90 дүгээр зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам

90.1. Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.

90.2. Шүүх хуралдаанд оролцогч мэдүүлэг, тайлбар өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно.

Хуралдаанд оролцогч өвчний улмаас хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаараа үг хэлэх буюу мэтгэлцэхэд оролцож болно.

90.3. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд орж ирэх, шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.

90.4. Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа шүүх хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны танхимаас гаргаж энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгуулж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

90.5. Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хуралдаан даргалагчийн захирамжаар тодорхой хугацаагаар хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлгийг сонсохгүйгээр хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж шүүх хуралдаан даргалагч буюу шүүгч үзвэл үргэлжлүүлэн явуулна. Уг этгээд хүсвэл шүүх хуралдааны үйл ажиллагааны талаар тэмдэглэлээс танилцуулж болно.



Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

34.20 дугаар зүйл. Шүүх хуралдааны дэг

1. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирэх, шүүхийн шийдвэр уншиж сонсгох үед шүүх хуралдааны танхимд байгаа хүмүүс бүгд босч шүүхэд хүндэтгэл үзүүлнэ.



2. Шүүх хуралдаанд оролцогч шүүхэд хандаж үг хэлэх, мэдүүлэг өгөхдөө суудлаасаа босно.

3. Шүүх хуралдаанд оролцогч хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.

4. Улсын яллагч, оролцогч шүүхийн шийдвэр уншиж сонсгоход байлцана.

5. Шүүх хуралдаанд оролцогч, шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүн шүүх хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахиулах шийдвэрт захирагдана.

Асуулт тавих

Шүүх хуралдаанд оролцогчдын мэтгэлцээн, тайлбар, няцаалт, асуулт, хэлсэн үгийг анхааралтай сонсож, ойлгомжгүй эсхүл ач холбогдолтой гэж үзсэн аливаа зүйлээ оролцогчдоос тодруулан асуух боломжтой.



Нотлох баримт шинжлэн судлахад оролцох

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны нотлох баримт шинжлэн судлах шатанд хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг шинжлэн судлуулах, асуулт тавих, даргалагчийн зөвшөөрлөөр хэргийн оролцогчдоос асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох эрхтэй.



Шүүх бүрэлдэхүүнд хүсэлт гаргах

Шүүхийн иргэдийн төлөөлөгч оролцогчдод асуулт тавих, үг хэлэх, хавтаст хэрэгтэй танилцахдаа шүүгчээс зөвшөөрөл авна. Түүнчлэн хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдааны танхимаас түр гарах, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн санал, дүгнэлтээ гаргах, бичих боломж нөхцөл олгох хүсэлтийг шүүх бүрэлдэхүүнд гаргаж болно.



ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Хараат бус байдал

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал гэдэг нь хэрэг маргааны үйл баримт, хэргийн бодит байдлыг тогтоох, дүгнэлт гаргахдаа хөндлөнгийн оролцоо, дарамт шахалтгүйгээр, аливаа хувийн ашиг сонирхол гаргахгүй байх явдлыг ойлгоно.



Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээд шүүхийн иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хуулиар хориглодог.



Нөлөөллийн мэдүүлэг

Шүүхийн иргэдийн төлөөлөгч танд хэрэг маргаантай холбогдуулан доорх болон өөр бусад арга, хэлбэрээр хөндлөнгөөс нөлөө үзүүлэх, таны хараат бус байдалд халдах аливаа оролдлого мэдэгдсэн буюу илэрсэн тохиолдолд энэ тухай шүүхийн Тамгын газрын ажилтанд яаралтай мэдэгдэж, нөлөөллийн мэдүүлэг бөглөнө. (Мэдүүлгийн загварыг 36-р хуудсаас харна уу)



Хөндлөнгөөс нөлөөлнө гэдэг нь:

Ганцаарчлан уулзах санал тавих

- Ганцаарчлан уулзах
- Утсаар ярих
- Захидал, зурвас бичих, гар утасны ба цахим зурвас илгээх
- Ойр дотны хүнээр зуучлуулах



Элдэв зүйл амлах

- Бэлэг, эд зүйл амлах,
- Үнэгүй үйлчилгээ, тусламж дэмжлэг үзүүлэх
- Хоолонд урих



Сүрдүүлэх

- Дарамт шахалт үзүүлэх
- Айлган сүрдүүлэх



ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН САНАЛ, ДҮГНЭЛТ

Саналаа нэгтгэх

Шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцож, иргэдийн төлөөлөгчид санал зөрвөл дүгнэлтээ тус тусдаа гаргаж болно.



Санал, дүгнэлтийн агуулга

Хэрэг болон хэргийн үйл явдлыг товчхон бичнэ.

- Эрүүгийн хэргийн хувьд: Шүүгдэгчийн гэм буруугийн тухай,
- Иргэний хэргийн хувьд: Нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн гэм буруугийн тухай,
- Захиргааны хэргийн хувьд: Захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар бичгээр санал, дүгнэлт гаргана.



Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үндэслэл, агуулга сайтай бичсэн санал, дүгнэлтийг шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа харгалзан үзэх, хэргийн оролцогчид өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрөх нэгэн чухал эх сурвалж болно. (Дүгнэлтийн загварыг 41-р хуудсаас харна уу)

Санал, дүгнэлтээ танилцуулах

Шүүхийн иргэдийн төлөөлөгч иргэн, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцвол дүгнэлт, харин эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцвол санал бичнэ.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргийн оролцогчдод санал, дүгнэлтээ уншиж танилцуулна.



Дүгнэлтийг бичгээр гаргах боломжгүй тохиолдолд санал, дүгнэлтээ амаар илэрхийлж, шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж болно.

Дүгнэлтийг үнэлэх

Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзана.

<p>Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.7</p>	<p>Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.</p>
<p>ЭРҮҮГИЙН ХЭРЭГ (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлийн 2.3)</p>	<p>Шийтгэх, цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт: “...иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл”-ийг бичнэ.</p>
<p>ЗАХИРГААНЫ ХЭРЭГ (Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.3)</p>	<p>Шийдвэрийн тодорхойлох хэсэгт: “...иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга”-ийг тусгана.</p>
<p>ИРГЭНИЙ ХЭРЭГ (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль)</p>	<p>Энэ талаар тусгагдаагүй</p>

Шийдвэрт дүгнэлтийг тусгаагүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДАРАА

Нууц хадгалах

Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараа шүүхийн иргэдийн төлөөлөгч төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх үүрэг хэвээр хадгалагдана.



Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс олгох

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хөлс болон албан томилолт, замын зардлыг шүүхийн төсвөөс олгоно. Шүүхийн ерөнхий зөвлөл, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 6/А3 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс болон албан томилолт, замын зардал олгох журам”-ын дагуу шүүхийн иргэдийн төлөөлөгчид шүүхэд ажилласан нэг цагийн хөлсийг нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгоно. Иргэдийн төлөөлөгчийн ажилласан цаг 8 цагаас бага бол ажлын 8 цагаар, 8 цагаас их бол ажилласан цагаар тооцно.



Томилолт болон замын зардлыг олгох

Шүүх байрлаж байгаа орон нутгийн засаг захиргааны нэгжээс алслагдмал зайтай аймаг, сум, баг, хорооноос шүүх хуралдаанд оролцохоор сонгогдсон, мөн шүүх хуралдаан дараагийн өдрүүдэд үргэлжлэхээр бол томилолт, замын зардлыг олгоно. Томилолтын зардлыг төрийн албан хаагчид олгох томилолтын зардлын жишгээр тооцно. Замын зардлыг нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлсэн тасалбар, тооцооны баримтыг үндэслэн олгоно.



Шүүхийн шийдвэртэй танилцах

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь өөрийн оролцсон шүүх хуралдаанаас бичгийн хэлбэрээр гаргасан шийдвэртэй танилцаж, шийдвэрт өөрийнх нь санал, дүгнэлтийг хэрхэн харгалзсаныг үзэж, танилцаж болно. Шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрх хуулиар олгогдоогүй.



АСУУЛТ, ХАРИУЛТ

1. Иргэний үнэмлэх олдохгүй, гээгдүүлсэн тохиолдолд шүүхэд ямар бичиг баримттай очих вэ?

Харьяа дүүргийнхээ Иргэний бүртгэлийн албанаас болон ТҮЦ машинаас иргэний үнэмлэхийн лавлагаа авч ирнэ.



2. Шүүх хуралдаан удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд завсарлага авахаар хүсэлт гаргаж болох уу?

Хэргийг хэлэлцэж эхлэхээс шийдвэрлэж дуусах хүртэлх хугацаанд шүүх хуралдаан тасралтгүй явагдана. Хэрэг маргаан нь ээдрээ төвөгтэй, олон оролцогчтой зэрэг шалтгааны улмаас зарим шүүх



хуралдаан хэдэн цагаар, өдрөөр үргэлжлэх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд шүүх хуралдаан даргалагч өөрийн санаачилгаар хуралдааныг түр завсарлуулдаг. Шүүхийн иргэдийн төлөөлөгч таны хувьд шаардлагатай тохиолдолд салхилах, цай, кофе уух, бие засах зэрэг асуудал гарвал хуралдаан даргалагчаас зөвшөөрөл хүсэх боломжтой.


3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхэд болон шүүх хуралдаанд очиж чадахгүй бол ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухайгаа шүүхийн Тамгын газарт даруй мэдэгдэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаан нь бичгийн нотлох баримтаар нотлогдсон байх шаардлагатай. Жишээ нь: эрүүл мэндийн нөхцөл байдлын улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол эмнэлгийн магадалгаагаар, бага насны хүүхэд болон бусад этгээдийг асран хамгаалж байгаа бол энэ талаарх хорооны Засаг даргын тодорхойлолт авах гэх мэт.



4. Шүүх хуралдаанд орохын тулд ажлаа яаж зохицуулах вэ?

Шүүхийн Тамгын газар шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд ажил олгогч нь шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа албан томилолтоос бусад тохиолдолд чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээнэ. Энэхүү хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй ажил олгогчид Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. (1 нэгж 1000 төгрөгтэй тэнцүү)



5. Шүүхэд ирмэгц хэнтэй уулзах вэ?

Шүүхийн Тамгын газрын ажилтан шүүхийн иргэдийн төлөөлөгч таныг угтаж, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримт, мэдэгдэх хуудсыг шалгаж, шүүх хуралдааны танхимд хүргэнэ.



6. Хэрхэн хувцаслах вэ?

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны оролцогч бөгөөд зохистой байдлаар хувцаслах нь шүүхийг хүндэтгэж буйн илрэл юм.



7. Шүүх хуралдаан эхлэхээс ямар хугацааны өмнө ирвэл зохих вэ?

Шүүх хуралдаан эхлэхээс өмнө тухайн хэрэг маргаантай танилцаж, шаардлагатай хэсгийг тэмдэглэн авах, түүнчлэн эрх, үүрэгтэйгээ танилцах учраас шүүх хуралдаан болохоос 1-ээс доошгүй цагийн өмнө шүүхийн байранд ирсэн байна.



8. Шүүхийн иргэдийн төлөөлөгч хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого гарсан үед ямар арга хэмжээ авах вэ?

Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс иргэдийн төлөөлөгчид аливаа

хэлбэрээр нөлөөлөхийг хуулиар хориглосон байдаг. Хэрвээ дээрх этгээд Танд ямарваа нэг байдлаар нөлөөлөхийг оролдвол “Нөлөөллийн мэдүүлэг” бөглөнө. Энэ нь таныг аливаа гадны хүчин зүйлээс хамгаалах юм. Нөлөөллийн мэдүүлгийн талаар шүүгчийн туслах Таныг мэдээллээр ханган ажиллана.



9. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хөлсийг хэрхэн тооцож олгодог вэ?

Шүүхэд ажилласан нэг цагийн хөлсийг нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгоно. Иргэдийн төлөөлөгчийн ажилласан цаг 8 цагаас бага бол ажлын 8 цагаар, 8 цагаас их бол ажилласан цагаар тооцно.



10. Шүүх хуралдаан хойшилсон үед хөлсийг хэрхэн тооцож олгодог вэ?

Танаас шалтгаалахгүйгээр шүүх хуралдаан хойшилсон бол шүүх хуралдаанд оролцсон, түүнчлэн хавтаст хэрэгт шинээр нэмэгдэж ирсэн материалтай танилцсан хугацааны хөлсийг журамд заасны дагуу олгоно.



11. Санал, дүгнэлтээ гараар бичих үү, компьютер ашиглан бичиж, хэвлүүлэх үү?

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн санал, дүгнэлтээ Та шүүгчийн туслахаас өгсөн хэвлэмэл хуудас дээр гараар бичнэ. Шаардлагатай тохиолдолд дүгнэлт, саналаа компьютер ашиглан бичиж, хэвлүүлэх боломжтой.



12. Санал, дүгнэлтээ зөвлөлдөж гаргах, бичих цаг хугацаа, нөхцөл боломжоор хангадаг уу?

Шүүх хуралдааныг түр завсарлуулах хүсэлтийг шүүх бүрэлдэхүүнд гаргаж болно. Завсарлагын үед зөвлөлдөж санал, дүгнэлтээ бичих боломжтой. Шүүхийн Тамгын газар нь зөвлөлдөх өрөө, бичих компьютер, хувилах төхөөрөмж, ажиллах нөхцөл, боломжоор хангана.



ОРОН НУТАГ, АЛСЛАГДСАН СУМААС ИРЭХ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АСУУДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ:

1. Алслагдмал зайтай баг, хорооноос шүүх хуралдаанд өөрийн унаагаар очиж оролцох үед зардлыг шүүхээс олгодог уу?

Замын зардлыг нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлсэн тасалбар, тооцооны баримтыг үндэслэн олгоно.



2. Тээврийн зардлаа урьдчилан авч болох уу?

Хэрэв та алслагдмал газраас шүүхэд очих унааны мөнгөгүй бол энэ талаараа тухайн шүүхийн Тамгын газарт мэдэгдэж, замын зардлаа урьдчилан авах боломжтой.



3. Алслагдмал зайтай баг, хорооноос шүүх хуралдаанд очиж оролцох үед томилолтын зардлыг шүүхээс олгодог уу?

Шүүх хуралдаан олон өдрөөр үргэлжлэхээр болсон тохиолдолд томилолтын зардлыг шүүхийн Тамгын газраас хүсэлт, томилолтын баримтыг үндэслэн төрийн үйлчилгээний албан хаагчид олгох томилолтын зардлын жишгээр тооцон олгоно.



4. Зочид буудлын зардлыг шүүх хариуцах уу?

Алслагдмал газраас ирж шүүх хуралдаанд оролцох тохиолдолд хоногийн зардлыг төрийн үйлчилгээний албан хаагчид олгох томилолтын зардлын жишгээр тооцон олгоно. Тусгайлан зочид буудалд байрласан зардлаар тооцохгүй.

